



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/389

Ховд

Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 65 дугаар зүйлийн 65.1.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 4.3, 4.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2020 оны 3 дугаар хуралдааны 3/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн орон нутгийн 2021 оны төсвийн Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 5:4-т тусгагдсан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн хөтөлбөрөөс 15,0 сая төгрөг /арван таван сая/-ийг зарцуулах эрхийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад шилжүүлсүгэй.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 15 000 000 /арван таван сая/ төгрөгийг “Хөшөөт хөгжил сан”-гаас тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөшөөт хөгжил сангийн захирал /Т.Мягмардорж/ нарт зөвшөөрсүгэй.

3. Эрх шилжүүлсэн хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, журмын дагуу тайлагнахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Г.Пүрэвганди/-д зөвлөсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 2122
D/Zah-A/389-Bo